



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 09 сарын 12 өдөр

Дугаар 1/309

Мандалговь

Орон тооны бус зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29 дүгээр зүйлийн 29.1.5 /д/ дахь заалт, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг: Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий аймгийн Засаг даргын дэргэдэх орон тооны бус зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Гишүүд: Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга

Эрүүл мэндийн газрын дарга

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга

Эрүүл мэнд, Нийгмийн даатгалын хэлтсийн дарга

Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн хөдөлмөр,

халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбооны тэргүүн

Аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн

холбооны тэргүүн

Нарийн бичиг: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга

Хоёр: Зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулж, жилийн ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын асуудал болон тэдний орчин нөхцлийг сайжруулах талаар үр дүнтэй ажил зохион байгуулж ажиллахыг орон тооны бус зөвлөл /Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ



0200868